

**МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН  
2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХАМТ ӨРГӨН  
МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН  
ТӨСЛҮҮДИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ  
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 11 дүгээр  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцүүлэхээр шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаараа дээрх хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэн дараах санал, дүгнэлтийг Та бүхэнд танилцуулж байна.

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт 25 хууль, З Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагч хэлэлцүүлгийн шатанд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөө татаан авсан болно.

Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль зүйн байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд хэлэлцэж санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт Төсвийн байнгын хороонд ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын даргын 2021 оны 82 дугаар захирамжаар Монгол Улсын 2022 оны төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд Төсвийн байнгын хороо тус ажлын хэсгээс болон Хууль зүйн байнгын хорооноос хууль, тогтоолын төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан саналыг нэгдсэн хуралдаанд танилцуулахаар Та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Ч.ХҮРЭЛБААТАР